

ГЕРМАН-МОНГОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ “ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ” ТӨСЛИЙН III ҮЕ ШАТНЫ 2019 ОНЫ ТАЙЛАН

2020 оны 02 дугаар сарын 28

№	Хөтөлбөр/ төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төслийн нэр: Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл MNG-19 01	Төслийн үндсэн /хөгжлийн/ зорилго: ХБНГУ болон Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх яриа хэлэлцээр, холбогдох үйл ажиллагаанууд нь Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарын эдийн засаг, нийгэм, экологийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлнэ.
2.	Санхүүгийн эх үүсвэр	ХБНГУ-ын Холбооны хүнс, хөдөө аж ахуйн яамны буцалтгүй тусламж
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Төслийг дэмжигч байгууллага: Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яам (ГФА Консалтинг групп яамыг төлөөлж төслийн ерөнхий захиалагчаар ажилладаг) Гол түншлэгч байгууллага: ХХААХҮЯ, ХААИС, УГТХ, МХЕГ, Үндэсний давхар даатгал ХК Хэрэгжүүлэгч байгууллага: ИАК Аграр Консалтинг ХХК-ийн удирдлагаар Агрикалче энд Файнэнс Консалтанс ХХК, ДЛЖ Интернэйшнл ХХК Хугацаа: 2019 оны 01 сараас 2021 оны 12 сар
4.	Төслийн зорилго, шалгуур үзүүлэлт	<p>Үр дүн 1: Газар тариалангийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах. Монгол улсын ХХАА-н салбарын эрх зүйн орчныг олон улсын жишигт ойртуулахад тодорхой ахиц гарсан бөгөөд энэ нь ялангуяа таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадал нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг тогтолцоог бий болгоход чиглэсэн хууль, эрх зүйн актуудад тусгагдсан байна.</p> <p>Үр дүн 2: Газар тариалангийн салбарын институцийн чадавхийг бэхжүүлэх. Монгол Улсын ХАА-н салбарын тогтвортой хөгжилд (ялангуяа таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадал нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг тогтолцоог бий болгоход) чухал үүрэгтэй боловч одоогоор хараахан бий болоогүй эсхүл үйл ажиллагаа нь төлөвшөөгүй төрийн эсхүл иргэний нийгмийн буюу хувийн хэвшлийн байгууллагуудыг бий болгох эсхүл чадавхижуулахад чиглэсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар салбарын институцийн орчны хөгжилд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Үр дүн 3: Газар тариалангийн салбарын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх. Монгол улсад таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадлыг нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг төлөвшүүлэхэд шаардагдах боловсон хүчний мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, улам гүнзгийрүүлэх, түгээн дэлгэрүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.</p> <p>Үр дүн 4: “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалан” дэд төсөл. Монгол Улс, ХБНГУ-ын газар тариалангийн салбар дахь мэдлэг, туршлага солилцоог идэвхижүүлэх замаар Монгол Улсад байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалангийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.</p>

5.	Зардал	Нийт төсөв	1,460,734 Евро /2019.01.01-2021.12.31 буюу нийт 36 сарын хугацаанд/				
		Тайлант хугацаанд зарцуулсан хөрөнгө	619.313,00 Евро (99,9 %) /2019 оны 1 сарын 1-ээс 2019 оны 12 сарын 31/				
		Үүнд:	2019.01-2019.12 Үндсэн төслийн санхүүжилтээр /Евро/	2019.04-2019.12 Нэмэлт төслийн санхүүжилтээр /Евро/	Нийт		
		Зөвлөх үйлчилгээнд (гадаад, дотоодын богино хугацааны мэргэжилтнүүд)	360,250.00	84,370.00	444,620.00		
		Танилцах аялал, талбайн өдөрлөг, сургалт, семинар, хурал зөвлөгөөн	80,108.00	47,522.00	127,630.00		
		Захиргааны зардал (төслийн нэгжийн урсгал зардал, унаа, харилцаа холбоо)	46,370.00	1,050.00	47,420.00		
		НИЙТ ДҮН /Евро/	486,728.00	132,942.00	619,670.00		
6.	Төслийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичсэн.					
	Үр дүн-1	Үнэлгээний тайлангийн 5 дугаар хуудас					
	Үр дүн-2	Үнэлгээний тайлангийн 5-6 дугаар хуудаснаас харна уу.					
	Үр дүн-3	Үнэлгээний тайлангийн 6-8 дугаар хуудаснаас харна уу.					
	Үр дүн-4	Үнэлгээний тайлангийн 8-9 дүгээр хуудаснаас харна уу.					
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Төслийн гүйцэтгэлд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээний хийхэд 92.5 хувьтай биелсэн байна.</p> <p>Тогтвортой хөдөө аж ахуй төслийн III дугаар үе шат хэрэгжсэнээр дараах бодит үр дүнгүүд гарч эхлээд байна.</p> <p>1. “Тариалангийн даатгалын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох урьдчилан тандан судлах судалгаа”, “ХАА-н зөвлөх үйлчилгээний хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа”-г хийсэн.</p> <p>2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн 2019-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн дэргэдэх Start-Up компани болох “Дархан Элит Үр” ХХК-ийн “Бизнес төлөвлөгөө”-г үндэсний зөвлөхүүдээр гүйцэтгүүлж, холбогдох талуудын оролцоотойгоор гүйцэтгэсэн.</p> <p>3. Монгол улсад таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадлыг нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг төлөвшүүлэх чиглэлд үр дүнтэй сургалтуудыг зохион байгуулсан байна.</p> <p>Зөвлөмж:</p> <p>1. Шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшинг тайлагнаж хэвших шаардлагатай байна.</p>					
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийг хэрэгжүүлэгч талууд боллоцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна.					
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (тухайн жилийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Үр дүн	Үр дүн 1	Үр дүн 2	Үр дүн 3	Үр дүн 4
		92.5	Хувь	100 %	70 %	100 %	100 %
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ ... %					

ТОВЧЛОЛ

ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ХААҮШҮОНТ	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв
ТХАА	Тогтвортой хөдөө аж ахуй
УГТХ	Ургамал, газар тариалангийн хүрээлэн (Дархан)
УХЭШХ	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн
МУИС	Монгол Улсын их сургууль
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ШУА	Шинжлэх ухааны академи
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХАБҮЛЛ	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори
ОУБ	Олон Улсын Байгууллага
ХАА	Хөдөө аж ахуй
УХЦА	Ургамал хамгааллын цогц арга
ЭША	Эрдэм шинжилгээний ажилтан

ТӨСЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮР ДҮН

Үр дүн 1: Газар тариалангийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах. Монгол улсын газар тариалангийн салбарын эрх зүйн орчныг олон улсын жишигт ойртуулахад тодорхой ахиц гарах бөгөөд энэ нь ялангуяа таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадал нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг тогтолцоог бий болгоход чиглэсэн хууль, эрх зүйн актуудад тусгагдсан байна.

А. Газар тариалангийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийсэн ажлууд: ХХААХҮЯ-наас байгуулсан “Жимс жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааварын төсөл” боловсруулах ажлын хэсэгт төслийн төлөөлөл орж ажилласан.

“Тариалангийн даатгалын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох урьдчилан тандан судлах судалгаа”-г хийсэн.

“ХАА-н зөвлөх үйлчилгээний хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа”-г хийсэн.

Огноо	Үйл ажиллагаа
2019.12	“Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн “Таримал ургамлын үрийн хянан баталгааны тухай” журмын төсөл боловсруулж, ХХААХҮЯ-нд хүлээлгэн өгсөн.
2019.12	“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалан” онол-үйлдвэрлэлийн бага хуралд оролцогчдоос гарсан саналуудыг нэгтгэн зөвлөмж боловсруулан ХХААХҮЯ-нд хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна.

Үр дүн-1-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 100 хувь

Үр дүн 2: Газар тариалангийн салбарын институцийн чадавхийг бэхжүүлэх. Монгол Улсын ХАА-н салбарын тогтвортой хөгжилд (ялангуяа таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадал нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг тогтолцоог бий болгоход) чухал үүрэгтэй боловч одоогоор хараахан бий болоогүй эсхүл үйл ажиллагаа нь төлөвшөөгүй төрийн эсхүл иргэний нийгмийн буюу хувийн хэвшлийн байгууллагуудыг бий болгох эсхүл чадавхижуулахад чиглэсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар салбарын институцийн орчны хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

Б. Газар тариалангийн салбарын институцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хийсэн ажлууд:

Огноо	Үйл ажиллагаа
2019.06	ХХААХҮЯ-ны харъяа Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв (ХААҮШУОНТ)-ийн 2019-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний төслийг ТХАА төслөөс санхүүжүүлэн Үндэсний зөвлөхүүдээр гүйцэтгүүлж, холбогдох талуудын оролцоотойгоор хэлэлцүүлэв. Хэлэлцүүлгийн явцад ирүүлсэн саналуудыг тусган эцэслэн ХААҮШУОНТ-д хүлээлгэн өгсөн.
2019.12	Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн дэргэдэх Start-Up компани болох “Дархан Элит Үр” ХХК-ийн “Бизнес төлөвлөгөө”-ний төслийг боловсруулсан.

Үр дүн-2-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 70 хувь

Үр дүн 3: Газар тариалангийн салбарын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх. Монгол улсад таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадлыг нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг төлөвшүүлэхэд шаардагдах боловсон хүчний мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, уг мэдлэг, ур чадварыг цаашид гүнзгийрүүлэх, түгээн дэлгэрүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

В. Газар тариалангийн салбарын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажлууд:

Огноо	Үйл ажиллагаа
2019.02.13-16	Монгол Улсын ХХААХҮЯ-ны холбогдох газруудын дарга, мэргэжилтнүүдийг хамруулсан органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн олон улсын туршлага судлах аяллыг ХБНГУ-д зохион байгууллаа. Тус аяллыг НБТГ-ын дарга М.Энх-Амар ахалж, органик хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн үзэсгэлэн болох BIOFACH 2019 (VIVANESS 2019 буюу органик гоо сайхны бүтээгдэхүүний) үзэсгэлэнгийн үйл ажиллагаа, олон улсын баталгаажуулалтын байгууллагууд, хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэлийн сүүлийн үеийн ололт амжилттай танилцан, салбарын 20 гаруй техникийн экспертүүдтэй мэргэжлийн яриа өрнүүлэн Монгол улсад органик ХХАА-н салбарыг хөгжүүлэх талаар хамтран ажиллах талаар санал солилцов.
2019.04.16-19	“Таримал ургамлын тарих үрийн чанар, аюулгүй байдал, хөдөө аж ахуйн зохистой дадал” сэдэвт сургалтыг МХЕГ, орон нутгийн МХГ-уудын таримал ургамлын үр, хорио цээр, ургамал хамгаалал, хилийн хяналтын байцаагчид болон үр, хөрс судлалын лабораториудын шинжээчид, ЭША-ууд зэрэг 70 гаруй мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулав.
2019.06.18-19	Тус төслөөс санаачлан 2018-2019 онд “Ургамал хамгааллын зохистой дадлын мэргэшүүлэх сургалтын концепц”-ийг УХЭШХ-тэй хамтран боловсруулсан бөгөөд энэ хүрээнд 2019 оны 06 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд Дархан-Уул аймагт ХХААХҮЯ, УХЭШХ, УГТХ-тэй хамтран “Ургамал хамгааллын зохистой дадал хэвшүүлэх сургагч багш бэлтгэх сургалт” зохион байгууллаа. Сургалтад ХААИС, УХЭШХ, УГТХ, ХААШУОНТ, Дархан-Уул аймгийн ХХААГ, Гацуурт ХХК, Эм Эс Эм ХХК-ийн багш, эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнууд болон ургамал хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтнүүд зэрэг нийт 18 хүн оролцож, сургагч багшийн сертификат гардлаа.
2019.06.20-21	ТХАА төслөөс ХХААХҮЯ-ны ГТБХЗГ, УХЭШХ, УГТХ, Дархан-Уул аймгийн ХХААГ-тай хамтран 2019 оны 06 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Дархан-Уул аймагт “Ургамал хамгааллын зохистой дадал дэлгэрүүлэх сургалт”-ыг зохион байгууллаа. Сургалтыг хөтөлбөрийг тус төслөөс УХЭШХ-ийн эрдэмтэн судлаачидтай хамтран боловсруулсан “Ургамал хамгааллын зохистой дадлын мэргэшүүлэх сургалтын концепц”-ийн агуулгын хүрээнд бэлтгэсэн бөгөөд онолын мэдлэгийг УХЭШХ-ийн эрдэмтэд, дадлага туршлагын ажлыг ХБНГУ-ын “Дойла-Нийнбург” сургалтын төвийн сургагч багш Рольф Сийлинг удирдан явууллаа. Тус сургалтад 50 гаруй хүн оролцлоо.
2019.06.28	Монгол Улсад Атар газрыг шинжлэх ухааны үндэслэлтэй эзэмшсэний түүхт 60 жилийн ойг угтах бүтээлч ажлын аяны хүрээнд ХХААХҮЯ, ТХАА төсөл болон УГТХ хамтран “Тариалангийн хөрсний менежмент, бордох технологи” семинарыг 2019 оны 6 дугаар сарын 28-нд Дархан хот дахь УГТХ-д зохион байгуулав. Хөрс хамгаалах тариалангийн технологи болон бордооны зохистой хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн тус семинарт Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Орхон аймгийн үр тариа, төмс, хүнсний ногоо үйлдвэрлэгчид, аймаг, сумдын агрономичдын төлөөлөл нийт 95 хүн оролцлоо.
2019.07.26	ТХАА төслөөс ХХААХҮЯ, ХААИС, УГТХ-тэй хамтран 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр “Хөрсний шинжилгээний арга, аргачлалын нэгдмэл байдал - Монгол, герман мэргэжилтнүүдийн туршлага солилцох уулзалт хэлэлцүүлэг”-ийг зохион байгууллаа. Тус уулзалт, хэлэлцүүлэгт УГТХ-ийн Хөрс, агрохимийн лаборатори, ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн Хөрс, агрохимийн лаборатори, ШУА-ийн Газарзүй – Геоэкологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори, МХЕГ-ын төв лаборатори, МУИС-ийн Хөрсний лаборатори, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, УХХ-ийн мэргэжилтнүүдээс гадна Инженер Геодези ХХК, Гацуурт ХХК, НАРТ ШУҮН Консалтинг ХХК-ийн Хөрсний итгэмжлэгдсэн лаборатори зэрэг

	хувийн компаниудын төлөөлөл болох 50 гаруй мэргэжилтнүүд, хөрс судлаачид оролцлоо.
2019.09.18-19	Таримал ургамын үрийн хянан баталгаажуулалтын тогтолцоог сайжруулж, хянан баталгаажуулалтыг найдвартай хийх нь газар тариалан эрхлэгчдийн хувьд олон жил эрүүл, найдвартай үрээр тариалах үндэс, түүнчлэн хэрэглэгчдийг эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хангах чухал ач холбогдолтой. Энэ хүрээнд ТХАА төслөөс ХХААХҮЯ, МХЕГ, УГТХ, Дархан-Уул Аймгийн ХХААГ, “Элит үр” ХХК-тай хамтран 2019 оны 09 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд Дархан-Уул аймагт “Үрийн төмсний чанарын хяналт” сэдэвт сургалтыг таримал ургамлын үрийн чанарын хяналтын байцаагчид, агрономичид, ЭША-нуудад зориулан зохион байгууллаа. Тус сургалтад 30 гаруй хүн оролцлоо.
2019.10.07-08	ТХАА төсөл, ХААҮШУОНТөв хамтран “Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээний сургагч багш бэлтгэх” эрчимжүүлсэн сургалтыг 2019 оны 10 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд ХХААХҮЯ-нд амжилттай зохион байгууллаа. Нэвтрүүлэх үйлчилгээний төлөвлөлт, хяналт-үнэлгээ, арга зүйн мэдлэг, практик ур чадвар олгоход чиглэсэн уг сургалтад Архангай, Баян-Өлгий, Дундговь, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Ховд аймгуудын зарим ХХААГ-ын дарга, нэвтрүүлэх үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүд, ХААҮШУОНТ-ийн мэргэжилтнүүд зэрэг 20 гаруй хүн оролцлоо.
2019.10.21-25	<u>Ургамлын үрийн шинж чанарыг олон улсын хэмжээнд зөв зүйтэй тогтоон мөн түүнчлэн тэдгээрийг баталгаажуулах явдал</u> нь үрийн шинжилгээний лабораторийн нөхцөл байдал, ажилтан мэргэжилтнүүдийн ур чадвар, хэрэглэж буй аргачлалаас ихээхэн хамаарна. Энэхүү ур чадварыг дээшлүүлэн дэмжих зорилгоор ТХАА төслийн хүрээнд Германы Захсэн-Анхалт мужийн Халле Хотын ургамлын үрийн шалган баталгаажуулах газартай хамтран 10-р сарын 21-25-ны хооронд долоо хоногийн сургалтыг тус газарт зохион байгууллаа. Уг сургалтад МХЕГ-ын ХАБҮЛЛабораторийн эрхлэгч Д. Энхтуяа, Сэлэнгэ аймгийн МХГ-ын лабораторийн эрхлэгч И.Ургамалсайхан нар хамрагдав.
2019.10.28-29	“Хүнсний ногооны аж ахуй эрхлэх зохистой дадал” сэдэвт Зүүн бүсийн тариаланчид, мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод зохион байгуулав. Тус 2 өдрийн сургалтад Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудын тариаланчид, мэргэжилтнүүд зэрэг нийт 90 гаруй хүмүүс хамрагдаа. Тус сургалтыг ХААИС, УГТХ, УХЭШХ, Сүхбаатар аймгийн ХХААГ-тай хамтран зохион байгуулсан.

Үр дүн-3-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 100 хувь

Үр дүн 4: “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалан” дэд төсөл. Монгол Улс, ХБНГУ-ын газар тариалангийн салбар дахь мэдлэг, туршлага солилцоог идэвхижүүлэх замаар Монгол Улсад байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалангийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

Г. “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалан” дэд төслийн хүрээнд хийсэн ажлууд:

Огноо	Үйл ажиллагаа
2019.05-2019.10	“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалангийн үйлдвэрлэл” сэдвээр олон улсын болон үндэсний богино хугацааны мэргэжилтнүүдийн оролцоотой судалгаа хийлээ.
2019.07.01-07	Тус дэд төслийн хүрээнд 2019 оны 07 дугаар сарын 01-07-ны хооронд Бүд Найрамдах Казакстан Улсад “Уур амьсгалын өөрчлөлт, газар тариалан” сэдэвт туршлага судлах аяллыг зохион байгуулсан. Энэхүү туршлага судлах аялалд ХХААХҮЯ, МХЕГ, УГТХ-ийн болон тариалан бүхий аймгууд болох Төв, Сэлэнгэ, Өвөрхангай аймгуудын ХХААГ-ын төлөөллүүд хамрагдсан. БНКУ нь байгаль уур амьсгалын хувьд манай улстай ижил нэг өргөрөгт

	байрладаг, далайд гарцгүй, эх газрын эрс тэс уур амьсгалтай зэрэг хоёр орны хувьд төстэй талууд олон байдаг.
2019.07-2019.09	“Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө газар тариаланд” сэдэвт салбарын мэргэжилтнүүд оролцсон ярилцлага, асуудал хөндсөн дүрс бичлэг/ баримтат видео сурвалжлага 3-ыг бэлтгэн олон нийтэд хүргэв.
2019.11.19-20	“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалан” онол-үйлдвэрлэлийн бага хурал зохион байгуулсан. Энэхүү хуралд ХХААХҮЯ, тариалан бүхий аймгуудын ХХААГ-ууд, МХЕГ, ХААИС, түүний харьяа сургуулиуд, хүрээлэнгүүд, тухайлбал, УГТХ, УХЭШХ болон газар тариалангийн ААН-үүд төлөөллүүд зэрэг нийт 90 орчим төлөөлөгчид оролцсон. Тус хурлаар “Газар тариаланд уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдлийг бууруулах, дасан зохицох арга замууд” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж, (а) салбарын бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдын төвшинд, (б) сургалт, эрдэм, шинжилгээ, судалгааны байгууллагуудын төвшинд, (в) хэрэгжүүлэх төвшинд буюу аж ахуйн нэгжүүд, тариаланчдын төвшинд хийх ажлуудыг дэс дараатай төлөвлөж, зохион байгуулж гүйцэтгэх талаар зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэв.
2019.12.03-04	“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тогтвортой газар тариалан” сэдэвт олон улсын зөвлөгөөнийг ХХААХҮЯ, БОАЖЯ-ны Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн, ХААИС, УГТХ, “Уур амьсгалын өөрчлөлт-хөгжлийн академи” ТББ, “Бүтлийн Ундарга” ХХК, ХБНГУ-ын Ханноверийн их сургууль, Шилжилтийн эдийн засагтай орнуудын хөдөө аж ахуйн хөгжлийн хүрээлэн, Бодлогын судалгааны тинк танк Эйч Эф Эф А Рисёрч ХХК, ХАА-н техник үйлдвэрлэгч “Амазон” компани зэрэг байгууллагуудын судлаач, мэргэжилтнүүд илтгэл хэлэлцүүлээ. Герман судлаачид Монгол улстай уур амьсгалын хувь төстэй “Сибирийн баруун өмнөд бүс болон Казакстаны хуурай тал нутагт тогтвортой газар тариалан хөгжүүлэх инновацийн судалгааны төсөл”, Киргизстан, Узбекистан улсуудад хэрэгжүүлж буй “Тариалангийн даатгалын тусламжтайгаар уур амьсгалын эрсдэл даван туулах чадварыг нэмэгдүүлэх” төслүүдийн үр дүнг танилцуулж, туршлагаа хуваалцсан. Түүнчлэн, УАӨ-ийн нөхцөл Монгол улсад зусах буудай, төмсний ургац 2050 он хүртэл хэрхэн өөрчлөгдөх загварыг танилцуулсан. Зөвлөгөөнд салбарын яам, харьяа агентлагууд, орон нутгийн Хүнс, хөдөө аж ахуй газрууд, мэргэжлийн ба эрдэм шинжилгээний байгууллагууд, олон улсын төсөл хөтөлбөрүүд, тариаланчдын төлөөлөл бүхийнийг 120 гаруй хүн оролцсон болно.

Үр дүн-4-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 100 хувь

Д. Төслийн хүрээнд зохион байгуулсан бусад ажлууд:

Огноо	Үйл ажиллагаа
2019.04.12	Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн гуравдугаар үе шат 2019 оны 01 дүгээр сараас эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд төслийн Удирдах хорооны ээлжит хурал 04 дүгээр сарын 12-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдлаа. Энэ удаагийн хуралд Германы талаас Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яам (ХХХААЯ), ГФА Консалтинг групп, төсөл хэрэгжүүлэгч ИАК Аграр Консалтинг ХХК-ийн төлөөлөгчид, ХБНГУ-ын Элчин сайдын яамны мэргэжилтэн болон Монголын талаас ХХААХҮЯ-ны холбогдох газар, хэлтсийн төлөөлөгчид, ХААИС-ийн удирдлага оролцлоо.
2019.08.29-09.01	Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яамны Парламент дахь Төрийн нарийн бичгийн дарга Ханс-Иоахим Фухтел тэргүүтэй төлөөлөгчид 2019 оны 08-р сарын 29-өөс 09-р сарын 01-ний хооронд Монгол Улсад албан айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр сайд Ч.Улаан төлөөлөгчдийг Монгол Улсад тавтай айлчлахыг хүсээд Монгол Улс, ХБНГУ-ын хүнс, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн

	<p>хөгжүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байгаад талархал илэрхийлэн Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яам, Монгол Улсын ХХААХҮЯ-ны хамтарсан “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл 2013 оноос хойш амжилттай хэрэгжиж байгааг онцлоод, хамтын ажиллагаагаа цаашид газар тариалангийн салбараас гадна мал аж ахуйн салбарт, тэр дундаа мал эмнэлгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийллээ. ХХААХҮ-ийн сайдын тавьсан саналыг Төрийн нарийн бичгийн дарга Ханс-Иоахим Фухтел нааштайгаар хүлээн авч мал эмнэлгийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг сургах, чадавхижуулах боломж бололцоо байгааг илэрхийлсэн бөгөөд ингэхдээ холбогдох байгууллагууд хооронд тэр дундаа Хөдөө аж ахуйн сургууль хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, харилцан мэргэжилтэн солилцох, туршлага хуваалцах зэрэг арга замуудыг онцлон тэмдэглэлээ.</p>
--	---

Е. Төслийн хүрээнд хийж буй бодлогын зөвлөмжүүд:

Огноо	Үйл ажиллагаа
2019.12	<p>Сүүлийн 6 жилийн байдлаар газар тариалангийн мэргэжлийн ангиудад элсэгчдийн тоо эрс багасчээ. Тухайлбал, 2014 оноос хойш “Жимс ногооны агроном” мэргэжлээр оюутан элсээгүй байна. Төрийн өмчийн болон төрийн өмчийн бус бүх их дээд сургуулиуд эдийн засгийн хувьд зөвхөн оюутны төлбөр дээр оршин тогтнодог тул шинээр элсэх оюутны тоо цөөрөх нь сургуулийн тогтвортой үйл ажиллагаанд маш ноцтой нөлөөлдөг. Иймд ТХАА төслөөс Газар тариалангийн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгох асуудалд сэдвээр “Бодлогын тойм” зөвлөмжийг шийдвэр гаргагчдад зориулан боловсруулсан.</p>
2019.12	<p>Газар тариаланд инноваци, тэр дундаа технологийн инноваци нэвтрүүлэх нь тариаланчдад чанартай арвин ургац хураан авах ихээхэн боломжийг бүрдүүлж байдаг. Ялангуяа хүний оролцоо ихтэй үйлдвэрлэлийн үе шатуудыг автоматжуулах, эрчим хүч зарцуулалт болон зардлыг багасгах нь бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулах, чанар стандартыг дээшлүүлэх ихээхэн орон зайг бий болгоно. Газар тариалангийн үйлдвэрлэлд технологийн инноваци нэвтрүүлэхийн ач холбогдол чиглэлээр “Бодлогын тойм” боловсрууллаа.</p>
2019.12	<p>ХХААХҮЯ-наас “Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээний тухай хууль”-ийг 2020 онд багтаан УИХ-д өргөн мэдүүлэхээр төлөвлөжээ. Тус хуулийн үзэл баримтлалын төсөлд хөдөө аж ахуйн салбарт хувийн хэвшил, ТББ-уудын идэвхитэй оролцоонд тулгуурласан олон оролцогч бүхий (плюралист) экстейншиний тогтолцоог бүрдүүлэх зорилтыг тусгасан бөгөөд ХХААХҮЯ болон салбарын бусад оролцогч талуудад цаашид нэвтрүүлэх үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх, дунд хугацааны бодлогыг тодорхойлоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ХАА-н экстейншиний үйлчилгээний олон оролцогч бүхий тогтолцоог бүрдүүлэхэд шийдвэрлэх асуудлууд сэдвээр “Бодлогын тойм” зөвлөмжийг боловсрууллаа.</p>